

**ЦАХИМ ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ҮҮССЭН ХОХИРЛЫГ
БАРАГДУУЛАХ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА****ENFORCEMENT PROCEEDINGS FOR COMPENSATION FOR
DAMAGES CAUSED BY CYBERCRIME****Ж.Чүлтэм**

*Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын
Хорих ял эдлүүлэх албаны холбоо, техник
ашиглалтын хэлтсийн телекамерын
инженер, ахлах дэслэгч*

Товч утга: Дэлхийн улс орнуудын хууль, эрх зүйн хөгжил нь нийгмийн хөгжлийнхөө үйл явцтай зэрэгцэн шинэчлэгдэж боловсронгуй болсоор байгаагийн тод жишээ нь цахим гэмт хэргийг эрүүгийн хуульдаа тусгаж өгсөн явдал юм. Мэдээллийн технологийн салбар өндөр хурдтай хөгжихийн хирээр цахим орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн үйлдэл илүү нарийсаж, энэ төрлийн гэмт хэргийг гэмт бүлэг, этгээдүүд нууц далд хэлбэрээр зохион байгуулсаар байна.

Цахим гэмт хэрэг үйлдэж, бусдад учруулсан хохирлыг барагдуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үйл явцын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, төлбөр төлөгдөхгүй байгаа шалтгаан нөхцөлийг тодорхойлж цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал гаргасан.

Түлхүүр үгс: Төлбөр төлөгч, техник технологи, цахим орчин, цахим хэрэгсэл, гэмт хэрэг, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, Эрүүгийн хууль, тайлан мэдээ,.

Abstract: A clear example of how the law and legal development of countries around the world continues to be updated and refined along with the process of social development is the inclusion of cybercrime in their criminal law. Due to the rapid development of the information technology sector, the crimes committed in the online environment have become narrower, and criminal groups and individuals continue to organize this type of crime in a secret and hidden manner.

Analyzing the current state of the decision enforcement process for cybercrimes and compensation for damages caused to others, the reasons and conditions for non-payment of payments were identified and suggestions were made for further implementation measures.

Keywords: Payer, technology, electronic environment, electronic tools, crime, decision enforcement, Criminal Law, reports.

Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийг тодорхойлбол, цахим мэдээллийн аюулгүй байдал, төр, хуулийн этгээд, иргэний мэдээллээ өмчлөх эрхэд гэм буруугийн санаатай хэлбэрээр цахим мэдээлэлд хууль бусаар халдах, цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлдэх, худалдан борлуулах, хор хөнөөлтэй программ хангамж бүтээх, ашиглах, тараах зэргээр халдсан, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай үзэгдэл юм.

Цахим гэмт хэргийн улмаас үүссэн хохирлыг барагдуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

Монгол улсын хувьд 2015 онд батлагдаж 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төлдөр мөрдөгдөж байгаа эрүүгийн хуулийн 17-р зүйлд “Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, **цахим хэрэгсэл ашиглаж**, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан бол дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”⁹¹, 13.10 дугаар зүйлд “Хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг хууль бусаар олж авсан, бусдад дамжуулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.... Энэ гэмт хэргийг... харилцаа холбоо, **цахим хэрэгсэл ашиглаж**; эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”⁹² гэж тус тус зааж өгсөн.


Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас хүн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг барагдуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, шүүхээс бичигдэж ирсэн гүйцэтгэх хуудсыг үндэслэн

⁹¹ Эрүүгийн хууль 2015 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2016 он, №07

⁹² Эрүүгийн хууль 2015 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2016 он, №07

шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар гүйцэтгэдэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт цахим гэмт хэрэг үйлдсэн 14 төлбөр төлөгчид холбогдох 1,5 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 31 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 953 сая төгрөгийн төлбөрийг бодитой биелүүлсэн байна. Дээрх төлбөрийн 60 орчим хувийг гадаад улсын иргэдээс учруулсан хохирол төлбөр эзэлж байна.



Дээрх гүйцэтгэх баримт бичгүүдийг гэмт хэргийн төрлөөр нь авч үзвэл:

- “Цахим сайтад орон сууц түрээслэх хуурамч зар байршуулж, урьдчилгаа мөнгө авсан” 9 буюу;
- “Бусдын цахим хаягт нэвтэрч, мөнгө эзэлдүүлэх хүсэлт гаргасан” 13;
- Залилах гэмт хэргийг цахим хэрэгсэл ашиглаж, зохион байгуулалттай гэмт бүлэглэл үйлдсэн” 8;
- Бусдын виза карт ашиглан мөрийтэй тоглоом тоглосон” 1 буюу 3 хувь байна.



Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн гэмт хэрэг үйлдэгдсэн этгээдэд битүүмжлэх хөрөнгө, орлогыг олж тогтоох зайлшгүй шаардлагатай байдаг. Хэрэв хөрөнгө орлого тогтоогдоогүй бол иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар хөрөнгө, орлогыг олж тогтоох, бусад этгээдэд үл хөдлөх, хөдлөх хөрөнгөө шилжүүлсэн эсэхийг шалгах албадлагын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Дээрх төлбөр төлөгчдийн 6 нь Монгол улсын иргэн, 8 нь БНХАУ-ын харьяат иргэд байна.



Төлбөр төлөгч гадаад улсын иргэд нь Монгол улсад оршин суух тодорхой хаяггүй, эрхэлсэн ажилгүй, өөрийн нэр дээрх хууль ёсны хөрөнгө бүртгэлгүй гэх мэт шалтгаануудтай байдаг учир иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахад хүндрэлтэй байдаг.

Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирол, төлбөрийг барагдуулахад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн өмчлөл, эзэмшлийн хөрөнгө, хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг битүүмжилсэн нөхцөл байдал нь албадлагын арга хэмжээний үр дүнд шууд нөлөөлж байдаг учраас шүүхээс гарах шийдвэрийн

биелэлтийг баталгаажуулах урьдчилсан арга хэмжээ авагдсан нөхцөл байдал нь хохирол, төлбөрийг шуурхай шийдвэрлэхэд гол үндэслэл, нөхцөлийг үүсгэдэг гэсэн үг юм⁹³.

Сүүлийн жилүүдэд цар тахлын нөхцөл байдал болон цахим орчны хэрэглэгчдийн эрэлт ихэссэнээс шалтгаалан цахим худалдааны олон төрөл бий болсон бөгөөд түүнд тохирсон эрх зүйн орчин хангалтгүй байгаа тул хуурамч цахим худалдааны хохирогч болсон иргэд элбэгших хандлагатай байна. Мөн цахим сүлжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн нэг болох мөрийтэй тоглоом тоглуулах зөрчил олширч байгаа нь Нийслэлийн прокурорын газраас гаргасан дараах судалгаагаар харагдаж байна.

Улсын хэмжээнд 2022 оны 9 дүгээр сард 230895 иргэн, 293 хуулийн этгээд Зөрчлийн тухай хуульд зааснаар шийтгүүлсэн ба зөрчил үйлдсэн хүмүүсийн 76 хувь нь эрэгтэй, 24 хувь нь эмэгтэй байгаа бол 64.4 хувь нь 26-45 насныхан байна энэ дотор мөрийтэй тоглоом зохион байгуулсан 16 зөрчил байгаа нь цаашид энэ тоо өдөр өдрөөр өсөх хандлагатай байгааг тод харуулж байгаа билээ.

Дүгнэлт

Цахим орчинд иргэд олон нийтийн сүлжээ ашиглан нийгмийн харилцаанд оролцохдоо хувийн мэдээллээ алдах, хэт хувийн чанартай мэдээллийг хууль бус аргаар олж авч олон нийтийн сүлжээнд тавих, тавихаар заналхийлэх, бусдыг үндэслэлгүйгээр гүтгэх, нэр төрд нь халдах, доромжлон гутаах, залилах зэрэг гэмт хэргийн золиос болж байна.

Кибер гэмт хэргийн гаралт ийнхүү нэмэгдэж байгаа нь Монгол Улсад кибер аюулгүй байдлыг хангах хууль эрх зүйн орчин хангалттай бүрдээгүйтэй холбоотой.

Гэмт хэрэг үйлдэж буй хүмүүс ихэвчлэн гадаад сервертэй веб сайтуудыг хэрэглэндээ ашигладаг ба тухайлбал Фейсбүүк, твиттер нь АНУ-д бүртгэлтэй компани бөгөөд эдгээрт бүртгүүлсэн хэрэглэгчийн мэдээлэл Америкийн хуулиар хамгаалагддаг, манай улсын хуулиар зохицуулагдах боломжгүй тул иргэн гомдол гаргасан тохиолдолд тэр улсаас нь тухайн сайтыг шалгаж өгөх, мэдээлэл авах хүсэлтийг явуулдаг, цахимаар үйлдэгдэж байгаа гэмт хэргийн мэдээллийг автоматаар олж авах технологийн боломж дэлхийн аль ч улсад хязгаарлагдмал байдаг тухай мэдээллийн технологийн мэргэжилтнүүд тайлбарлаж байна.

Мөн Фейсбүүк /Facebook/ компани нь терроризм, хүний амь нас хохирох нөхцөл байдал бий болсон, хүүхдийн садар самуун, секс сүрдүүлэг, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг /хар тамхи, хүн худалдаалах, мөнгө

⁹³ Өнөрмаа.Б 2022 он. Цахим хэрэгсэл ашиглан үйлдэгдэж буй гэмт хэргийн шалтгаан нөхцөл, эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлага нийтлэл. Монголын хуульчдын холбооны веб сайт.

угаах/ зэрэг тодорхой төрлийн цөөн хэргээс бусад хэрэгт мэдээлэл гарган өгдөггүй нь олон төрлийн гэмт хэргийг таслан зогсооход хүндрэл учирдаг байна.

Цахим гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд нь төлбөрийн чадваргүй, оршин суух хаяггүй, өөрийн өмчлөлд бүртгэлтэй эд хөрөнгө байхгүй, хуулийн дагуу орлого олдоггүй, өөрийн нэр дээрх банкны дансаар гүйлгээ хийдэггүй зэрэг шалтгааны улмаас төлбөр төлүүлэх ажиллагаанд саад учирч байна.

Цахим хэрэгсэл ашиглан үйлдэж буй гэмт хэргийг таслан зогсоох, иргэдийг халдлагаас хамгаалахын тулд эрх зүйн орчныг бүрдүүлэх нь нэн түрүүний асуудал болж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн гэмт хэрэг үйлдэгдсэн этгээдэд битүүмжлэх хөрөнгө, орлогыг олж тогтоох зайлшгүй шаардлагатай байна. Ингэснээр төлбөр барагдуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд нэлээдгүй ахиц гарах болно.

Санал

Дээрх судалгаа дүгнэлтэд цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр дараах саналуудыг гаргаж байна. Үүнд:

1. Эрх зүйн орчныг бүрдүүлэх гол нөхцөл нь өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн зохицуулалтад дүн шинжилгээ хийх, сүүлийн 3 жилийн байдлаар энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хүн, халдлагад өртсөн хохирогчийн нийгэм хүн ам зүйн шинж, гэмт хэрэг үйлдсэн орчин нөхцөл зэргийг бүрэн хамруулсан суурь судалгааг мэргэжлийн байгууллагууд хамтран хийх;

2. Цахим хэрэгсэл ашиглан гэмт хэрэг /бусдыг заналхийлэх, цахим орчинд бусдыг доромжлох, цахим хэрэгсэл ашиглан хүүхдийн эсрэг хууль бус үйлдэл хийх, эрсдэлт нөхцөлд оруулах зэрэг/ үйлдэж байгааг Эрүүгийн хуульд заасан үндсэн гэмт хэргийн хүндрүүлэх шинж болгон тусгах;

3. Цахим орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх;

4. Цахим орчинд хүүхдийн эсрэг чиглэсэн аливаа төрлийн хүчирхийлэл, хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө бүхий мэдээллийг зориуд түгээсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцож хуульчлах шаардлагатай байна.

5. Цахим худалдаа, цахим сугалааны эрх зүйн орчныг бүрдүүлэх;

6. Мөрдөгч нар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн гэмт хэрэг үйлдэгдсэн этгээдэд битүүмжлэх хөрөнгө, орлогыг олж тогтоох зайлшгүй шаардлагатай байна.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. Эрүүгийн хууль /2015 он/
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /2017 он/

3. НШШГГ-ын мэдээ, тайлан 2022 оны 09 сарын байдлаар
4. Эрүүгийн эрх зүйн тусгай анги 2018 он
5. Монгол улсын эрүүгийн хуулийн тайлбар 2013 он
6. Монгол улсын Ерөнхий прокурорын газрын цахим

---o0o---